

## НҮҮРС ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

Дугаар ШО23-1/05

2023/45

2023 оны 06 дугаар сарын 08 өдөр

Сэвхүүл

Нэг талаас “Шивээ-Овоо” ХК-ийг төлөөлж Ерөнхий инженер Г.Гэрэлхүү /цаашид Худалдагч гэх/ нөгөө төлөөс “Амгалан дулааны станц” ТӨХК-ийг төлөөлж Ерөнхий инженер Э.Мөнхжаргал /цаашид Худалдан авагч гэх/ нар Компаний тухай хуулийн 80, 83 дугаар зүйл, Иргэний хуулийн 243-261 дүгээр зүйлийг үндэслэн энэхүү гэрээг дараах нөхцлийн тохиролцож байгуулав.

### Нэг. Нийтлэг зүйл

1.1 “Шивээ-Овоо” ХК /цаашид Худалдагч тал гэх/ нь “Амгалан дулааны станц” ТӨХК /цаашид Худалдан авагч тал гэх/-д гэрээний хугацаанд 260000 /Хоёр зуун жаран мянга/ тонн нүүрсийг хавсралтанд заасан хуваарийн дагуу гэрээнд заасан үнээр нийлүүлнэ.

1.2 Гэрээний хугацаанд Худалдагч нь гэрээний 2.1-д заасан стандартын шаардлагад нийцсэн нүүрсийг гэрээний хавсралтад заасан хуваарийн дагуу нийлүүлэх, Худалдан авагч нь нийтүүлсэн нүүрсний төлбөрийг гэрээнд заасан хуваарийн дагуу төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

1.3 Нүүрсний тооцоог 2 талын нягтлан бодогч нар дараа сарын 3-ны дотор хийж актаар баталгаажуулна.

1.4 Энэхүү гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай саналаа талуудын оролцоотойгоор тухай бүрд нь шийдвэрлэнэ. Шийдвэрийг бичгээр гаргана.

### Хоёр. Худалдагч талын үүрэг, эрх, хариуцлага

2.1 Худалдагч тал нь MNS5096-2016 стандартад нийцсэн нүүрсийг хавсралтанд заасан хуваарь болон сар бүрийн УБТЗ-ын ачаа тээврийн төлөвлөгөөний дагуу нийлүүлнэ. Худалдан авагч талын зуухны горимын дагуу чийглэг нь 38%-аас ихгүй, илчлэг нь 3000 ккал/кг-аас багагүй, технологийн дамжлагаар оруулан ангилж буталсан 0.01-200 мм-ийн бутармагтай байна.

2.2 Нүүрсийг техникийн паспортын дагуу вагоны даацанд хүргэж ачих үүрэг хүлээнэ.

2.3 Худалдагч талын давагдашгүй хүчин зүйлийн үйлчлэлийн улмаас нүүрс нийлүүлэх боломжгүй болсон тохиолдолд Худалдан авагч талд 7-10 хоногийн өмнө урьдчилан мэдэгдэнэ.

2.4 Худалдагчийн илгээсэн нүүрс, Худалдан авагч талын хүлээн авсан нүүрсний чийглэг, үнслэг, дэгдэмхий бодис, хухэрлэг, илчлэгийн өдөр бүрийн вагонаас дээж авч лабораторийн шинжилгээ хийнэ. Хоёр талын магадлан итгэмжлэгдсэн лабораторийн нүүрсний шинжилгээний дүнг сарын дундажаар тооцож, тооцоонд ашиглана. Шинжилгээний дунгийн тоон утгын дунджийг арифметикийн дунджаар гаргана.

2.5 Нүүрсний овор хэмжээ болон чанар зөрчигдөх, вагон ачилт дундуур, төмөр, механик хольц, шавар, чулуу, шороо, хайрга ачигдаж ирсэн тохиолдолд тэдгээрийн улмаас үүсэх хохирлыг талуудын төлөөлөгчид станц дээр очиж холбогдох хүмүүсийг байлцуулан комисс томилж акт тогтоож шийдвэрлэнэ. Буруутай тал хохирол, гарсан зардлыг бүрэн хариуцна.

2.6 Худалдагч талын падаан бичигч нь төмөр замын Ачаа тээврийн үйлчилгээний цахим систем(АТҮЦС) программ ашиглан бичиг баримтуудыг цахимаар солилцож үнэн зөвөөр бичиж хугацаанд нь Хүлээн авагчид илгээнэ. Энэ нь тооцоо нийлэх үндсэн баримт болно.

2.7 Худалдан авагч талын шаардлагаар нийлүүлэх нүүрсний фракц болон нүүрсийг хатаалгын горимд оруулсан, ангилсан чанартай нүүрсээр хангана.

2.8 Худалдан авагч талаас шалтгаалан хуваарийн дагуу нүүрсийг нийлүүлж чадаагүй тохиолдолд нийлүүлээгүй нүүрсийг худалдагч тал дараа саруудад нөхөн нийлүүлнэ.

2.9. Хоёр тал стандартын дагуу вагоны цуваа бүрээс сорыц авч өөрсдийн лабораторуудад шинжлүүлж илчлэг, бусад үзүүлэлтийг тооцож болно. Нүүрсний шинжилгээний дүнг талууд 7 хоног бүрийн “Даваа” гаригт цахимаар харилцан мэдээлж байна.

2.10 Дулааны станцын төмөр замын хүчин чадалд тааруулж уурхайгаас нүүрстэй вагоныг тогтмол 8 буюу 16, 24, 32, 40 вагоныг өдөр, шөнийн ээлжинд цуваагаар явуулж байх.

2.11 2750 ккал/кг-аас доош илчлэгтэй, 200мм-ээс дээш бүхэллэгтэй /фракцтай/ нүүрсийг Худалдан авагч талын вагон хөмрөгчийн решёткаар хүлээн авах боломжтүй бол нүүрстэй вагоныг Худалдагч талын төлөөлөгчид хүлээлгэн өгч буцаана. Нүүрсний бүхэллэгийн хэмжээ 200мм-ээс дээш нийлүүлэгдсэн нүүрсний 15 хүртэл хувь байж болно. Энэ тохиолдолд худалдагч худалдан авагч тал дээрх үндэслэлээр буцаах эрхгүй. Харин 200мм-ээс дээш бүхэллэгтэй нүүрсний хэмжээ, нийлүүлэгдсэн нүүрсний 15 хувиас хэтэрсэн тохиолдолд хаяг солихтой холбогдо гарах тээврийн бүхий л зардлыг Худалдагч тал хариуцна.

#### *Гурав. Худалдан авагч талын үүрэг, эрх, хариуцлага*

- 3.1 Гэрээнд заасан хугацааны дотор худалдан авсан нүүрсний үнийг төлөх үүрэгтэй.
- 3.2 Гэрээгээр тогтоосон чанар стандартад нийцсэн нүүрс нийлүүлэхийг шаардах эрхтэй.
- 3.3 Гэрээгээр тохиролцсон 260000 тонн нүүрсийг хүлээн авч, нийлүүлэх цэгээс /Шивээ Овоо өртөө/ цаашхи тээвэрлэлттэй холбоотой зардал, хариуцлагыг хүлээнэ.
- 3.4 Хавсралтад заасан нүүрсний хэмжээнд өөрчлөлт оруулах тохиолдолд Худалдагч талд урьдчилан 7-с доошгүй хоногийн өмнө албан бичгээр болон мейлээр мэдэгдэнэ.

3.5 Нийлүүлэгдсэн нүүрс гэрээний 2.1-д заасан шаардлага хангаагүйн улмаас Худалдан авагч талын тоног төхөөрөмжид эвдрэл, саатал гарч компанийд хохирол гарсан тохиолдолд 2.5-д зааснаар комисс томилж акт тогтоож хохирлыг нэхэмжилнэ.

3.6 3000ккал/кг-аас бага илчлэгтэй, механик хольцтой, чийглэг нь 38%-аас дээш гарсанаас болж хөлдөж наалдсан, шавар, чулуу, шороо, үнслэгийн хэмжээ нь зөвшөөрөгдсөн хэмжээнээс их ирсэн тохиолдолд УБ хотод суугаа төлөөлөгчид мэдэгдэн харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

3.7 Нүүрсний жинг Худалдагч, Худалдан авагч 2 талын баталгаат вагон жингийн хэмжилтийн дунджаар тооцно. Хэрэв аль нэг талын вагон жингийн хэмжээ нь зөвшөөрөгдсөн хэмжээнээс их хувийн ажиллагаатай байгаа вагон жингээр тооцож байна. Вагон жингийн баталгаажилтыг хугацаанд нь хийлгэж гэрчилгээг харилцан солилцож мэдээлж байна.

3.8 Нүүрсний суурь илчлэгийг 3000 ккал/кг тооцно. Нүүрсний суурь илчлэг 3000 ккал/кг-аас буурсан, өссөн тохиолдолд нүүрсний илчлэгт үнийн зөрүү тооцно.

3.9 Хоёр тал стандартын дагуу вагоны цуваа бүрээс сорьц авч өөрсдийн лабораторуудад шинжилгээ хийж илчлэг, бусад үзүүлэлтийг лабораториудын шинжилгээний дунджаар тооцно.

3.10. Гэрээний 2.8-д зааснаар нөхөн нийлүүлсэн болон хавсралт 1-д заасан хуваарийн дагуу нийлүүлэгдэх нүүрсийг худалдан авагч тал хүлээн авах үүрэгтэй. Худалдан авагч талын буруутай шалтгаанаар гэрээний хавсралтад заасан болон нөхөн нийлүүлэгдэх нүүрсийг нийлүүлээгүй бол худалдагч талд учирсан хохирлыг барагдуулах үүрэг хүлээнэ.

#### *Дөрөв. Төлбөр тооцоо, талуудын хүлээх үүрэг*

4.1 Нүүрсний суурь илчлэгийг 3000 ккал/кг-аар, 1 тонн нүүрсний үнийг 38990 төгрөгөөр тооцно. НӨАТатварыг 1 тонн нүүрсний үнэ бүр дээр нэмж тооцно.

4.2 Худалдан авагч тал нь тухайн сард нийлүүлэгдэх нүүрсний төлбөрийн тооцоо нийлж дараа сарын 15-ны өдрийн дотор Худалдагч талын харилцах дансанд бүрэн шилжүүлнэ. Төлбөрийг хугацаанд нь төлөөгүй тохиолдолд нийлүүлсэн нүүрсний үнийн төлөгдөөгүй үлдсэн үнийн дүнгээс хугацаа хэтэрсэн хоног тутамд 0.1%-ийн алданги тооцож төлнө. Мөн гэрээний 2.8, 3.10-д заасан үүргээ худалдан авагч тал гүйцэтгээгүй тохиолдолд нөхөн нийлүүлэгдэх болон гэрээний хавсралт 1-д заасан нүүрс нийлүүлэх хуваарийн зөрчигдсөн хэмжээгээр нүүрсний үнийн дүнгийн 0.1%-аар хоног тутамд алдангийг худалдагч талд төлнө. Худалдагч тал нь гэрээний дагуу сард нийлүүлэх нүүрсээ давагдашгүй хүчин зүйл болон гэрээний 2.8, 3.10, 4.6-д зааснаас бусад шалтгаанаар бүрэн гүйцэд нийлүүлээгүй тохиолдолд дутуу нийлүүлсэн нүүрсний үнийн дүнгийн 0.1%-аар хоног тутамд алдангийг Худалдан авагч талд төлнө. Алдангийн нийт хэмжээ төлбөл зохих нийт төлбөрийн 20%-аас хэтэрч болохгүй.

4.3 Талууд сарын хуваарийн дагуу захиалга, нүүрсний нийлүүлэлт, хүлээн авалтыг жигд хийж байх ба тэдгээрийг гүйцэтгээгүйн улмаас үүсч болох хохиролыг буруутай тал хүлээнэ.

4.4 Худалдан авагч тал нь Худалдагч талын албан бичгээр гаргасан хүснэгтийг үндэслэн Худалдагч талын өмнөөс холбогдох байгууллагатай хийх төлбөрийг суутган тооцож болно.

4.5 Эрчим хүчний зохицуулах хороо болон ТҮЗ-ийн шийдвэрээр үнэ нэмэгдүүлэх шийдвэр гарсан тохиолдолд тухайн нэмэгдүүлсэн өдрөөс эхлэн шинэчилсэн тарифаар төлбөр тооцоо хийнэ.

4.6 Гэрээний 4.2-т заасан хугацаанд худалдан авагч төлбөрийг бүрэн барагдуулаагүй тохиолдолд ажлын 5 хоногийн дотор төлбөр нэхэмжлэх мэдэгдэл Худалдагч талаас хүргүүлнэ. Худалдан авагч тал төлбөрийн нэхэмжлэх хүлээн авснаас хойш ажлын 5 хоногийн дотор төлбөрийг бүрэн барагдуулаагүй тохиолдолд дараагийн нийлүүлэлтийг зогсооно.

#### *Тав. Давагдашгүй хүчин зүйл*

5.1 Худалдагч ба Худалдан авагч талууд гэрээнд заагдсан үүргээс бүрэн ба хагас чөлөөлөгдөх нөхцлиүүд байна. Тус гэрээний биелэлтэд нөлөөлж, үүргээ давагдашгүй хүчин зүйлийн улмаас биелүүлэх боломжгүй нөхцөлд. Үүнд: гал түймэр, үер, газар хөдлөлт ба дайны үйл ажиллагаа. Ийм нөхцөлд давагдашгүй хүчин зүйл, түүний үр дагавар дуусах хүртэл тус гэрээний биелэлтийн хугацаа сунгагдана.

5.2 Давагдашгүй хүчин зүйлийн улмаас гэрээний үүргээ биелүүлж чадахгүй болсон тал давагдашгүй хүчин зүйл эхэлснээс 2 хоногийн дотор нөгөө талд бичгээр мэдэгдэнэ.

5.3 Давагдашгүй хүчин зүйл тохиолдсоныг Худалдаа аж үйлдвэрийн танхимын албан бичиг (тодорхойлолт) нотолно.

### Зургаа. Бусад нөхцөл

6.1 Хөрөглэгчдийн эрчим хүчний осоп нэмэгдэж байгаа хөрөгцөг хангах зорилгоор төлөвлөгөөнөөс илүү үйлдвэрлэл явуулахад технологийн хэрэгцээний нүүрс нэмж шаардагдвал энхүү гэрээний хавсралтад нийлүүлэх нүүрсний хуваарьт албан бичгээр өөрчлөлт оруулж мөрднө.

6.2 Технологийн saatал, осол гарах, техникийн хүндрэл гарах зэрэг тохиолдолд гэрээ хийсэн талуудын төлөөлөгчид хамтран хэлэлцэж саадыг даван туулах, гэрээний заалтад өөрчлөлт оруулах шийдвэрийг албан бичгээр гаргана. Энэ шийдвэр нь гэрээний эцсийн биелэлтэнд нөлөөлөхгүй.

6.3 Энэхүү гэрээг 2023 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 2024 оны 06 дугаар сарын 01-ний өдөр хүргэх хүчинтэй байна. Гэрээг сунгаж болно. Гэрээ нь харилцан баталсан өдрөөс хүчин төгөлдөр болж мөрдөгднө.

6.4 Гэрээг улирал бүр дүгнэх бөгөөд 2 тал харилцан тохиролцож гэрээ дүгнэсэн акт үйлдэнэ.

6.5 Гэрээний хувь нь Худалдагч тал, Худалдан авагч талд тус бүрд 2 хувиар хадгалагдах бөгөөд гэрээтэй холбогдсон, акт албан бичгийн хувиудыг талуудад хадгалагдана. Гэрээ дүгнэсэн, сунгасан, нэмэлт оруулсан баримт бичгүүд нь энхүү гэрээний салшгүй хэсэг болно.

6.6 Талууд сарын хуваарийн дагуу вагон захиалалт, нийлүүлэлт, татан авалтыг шуурхай гүйцэтгэж гэрээний үүргээ биелүүлэх ба аль нэг талын буруутай үйл ажиллагаанаас үүссэн хохирлыг буруутай тал нь хүлээнэ.

6.7 Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж, мөрлөж ажиллах бөгөөд гэрээтэй холбоотой маргаан гарвал 2 тал аль болох эвийн журмаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ. Хэрэв тохиролцохгүйд хүрвэл шүүхэд асуудлыг тавьж шийдвэрлүүлнэ.

### Долоо. Гэрээг цуцлах

7.1. Гэрээг хуульд зааснаас гадна дараах үндэслэлээр нэг талын санаачлагаар цуцлах болно.


А. Аль нэг тал гэрээ ба хуулиар хүлээсэн үүргээ удаа дараа зөрчсөн ба үүнээс болж нөгөө тал нь хохирол хүлээсэн нь баримтаар нотлогдсон бол хохирол хүлээсэн талын санаачлагаар.

Б. Нүүрсний чанарын үзүүлэлт гэрээнд заасан үзүүлэлт зөрчигдэж байгаа бол Худалдагчид албан тоотоор мэдэгдэж чанарын үзүүлэлтийг сайжруулахгүй бол Худалдан авагчийн санаачлагаар гэрээг цуцлана.

В. Худалдагчийн нийлүүлэх нүүрсний нөөц дууссан буюу Худалдагч гэрээгээр хүлээсэн нүүрс нийлүүлэх үүргээ биелүүлэх боломжгүй бол 7-10 хоногийн өмнө Худалдан авагч талд албан тоотоор мэдэгдэж гэрээ цуцлах эрх үүснэ.

## ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

## ХУДАЛДАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

  
С.Цасчихэр  
Санхүү хариуцсан тэргүүн дэд  
захирал

  
Г.Гэрэлхүү  
Ерөнхий инженер

  
Б. Эрдэнэбаяр  
Ерөнхий технологич, Технологи  
бодлогын хэлтсийн дарга

## ХУДАЛДАН АВАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

  
Э.Мөнхжаргал  
Ерөнхий инженер

  
Ө.Удвал  
СЭЗХ-ийн дарга, Ерөнхий нягтлан  
бодогч

  
Э.Ариунболд  
Зуухан цехийн дарга

  
Д.Түвшинзаяа  
Түлш дамжуулах цехийн дарга

  
Б.Батцоож  
Гэрээ, борлуулалтын инженер

  
Г.Саруул  
Хуулийн мэргэжилтэн

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх  
дүүрэг  
8-р хороо, УС-15-1-1  
“Амгалан дулааны станц” ТӨХК  
Утас: 77111252, 99103310, 99662289  
Факс: 77111253  
Данс: Төрийн банк 106000036534  
Хаан банк 5131101050  
Голомт банк 3105103284  
Капитрон банк 3003012002

Хаяг: Говьсүмбэр аймаг, Шивээговь сум  
42020 Сэвхүүл  
Утас: (976)-7054-6464  
Факс:(976)-7054-6363  
Данс: Төрийн банк 106030085487  
Голомт банк 1905141024


2023 оны 5-р сарын 29-ний  
өдрийн ШО23-1/05 тоот гэрээний  
хавсралт №1

**2023-2024 онд “Шивээ-Овоо” ХК-аас нийлүүлэх нүүрсний хуваарь**

| Д/д | Он, сар      | Жин /тонн/                               |
|-----|--------------|--|
| 1   | 2023-2024 он | 09 сар                                   |
| 2   |              | 10 сар                                   |
| 3   |              | 11 сар                                   |
| 4   |              | 12 сар                                   |
| 5   |              | <b>2023 оны сүүлийн хагас жилийн дүн</b> |
| 6   |              | 01 сар                                   |
| 7   |              | 02 сар                                   |
| 8   |              | 03 сар                                   |
| 9   |              | 04 сар                                   |
|     |              | 05 сар                                   |
|     |              | <b>2024 оны эхний хагас жилийн дүн</b>   |
|     |              | <b>Нийт дүн</b>                          |
|     |              | <b>20,000.0</b>                          |
|     |              | <b>20,000.0</b>                          |
|     |              | <b>20,000.0</b>                          |
|     |              | <b>46,000.0</b>                          |
|     |              | <b>106,000.0</b>                         |
|     |              | <b>50,000.0</b>                          |
|     |              | <b>38,000.0</b>                          |
|     |              | <b>34,000.0</b>                          |
|     |              | <b>29,000.0</b>                          |
|     |              | <b>3,000.0</b>                           |
|     |              | <b>154,000.0</b>                         |
|     |              | <b>260,000.0</b>                         |

**ХУВААРЬ ГАРГАСАН**

**ХУДАЛДАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

  
 Б.Эрдэнэбаяр  
 Ерөнхий технологич, Технологи  
 бодлогын хэлтсийн дарга

**ХУДАЛДАН АВАГЧИЙГ  
ТӨЛӨӨЛЖ:**

  
 Б.Батцоож  
 Гэрээ, борлуулалтын инженер